

## **БНХАУ-ын “Цаг уурын хиймэл дагуулын бүтээгдэхүүн” сэдэвт олон улсын цахим сургалтанд хамрагдсан товч тайлан**

2020.12.14

Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл үйлчилгээний хэлтсийн ахлах синоптик инженер Б.Тэмүлүн, Б.Батцэцэг, Б.Солонго, синоптик инженер П.Хэрлэнчимэг, Ц.Аззаяа нар 2020 оны 09-р сарын 14-нөөс 25-ны хооронд Хятадын цаг уурын албанаас зохион байгуулсан “Цаг уурын хиймэл дагуулын бүтээгдэхүүн” сэдэвт 50 цагын цахим сургалтанд суусан.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь цаг агаарын урьдчилсан мэдээнд хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг ашиглах чадвар эзэмших, цаг уурын хиймэл дагуулын сүүлийн үеийн шинэчлэгдсэн бүтээгдэхүүнийг судлах, суралцахад оршино.

### **Сургалт агуулга:**

- Хятадын цаг уурын байгууллага, сургалтын төвтэй товч танилцах
- FУ хиймэл дагуулын бүтээгдэхүүний танилцуулга болон хэрэглээ
- Цаг уурын хиймэл дагуулын програм
- FУ байран хиймэл дагуулын хэрэглээ, танилцуулга
- Хиймэл дагуулын мэдээлэл цуглуулах, түгээх үйлчилгээ
- Хиймэл дагуулын цаг агаарын хэрэглээний платформ хувилбар 2.0-ын танилцуулга
- SMART системийн танилцуулга
- Хятадын цаг уурын байгууллагын CAST системийн танилцуулга
- Цаг уур, уур амьсгалыг хиймэл дагуулын бичил долгионы тусламжтайгаар зайнаас тандан судлах
- Хэт богино хугацааны прогнозд хиймэл дагуулын өгөгдлүүдийг ашиглах
- Хиймэл дагуулын өгөгдлүүдийг тоон прогнозд ашиглах
- Хиймэл дагуулын бүтээгдэхүүнүүдийн хэрэглээний ерөнхий танилцуулга
- Цаг уурын гамшигт үзэгдлийн үед хиймэл дагуулын мэдээллийг ашиглах
- Австралийн Хятадын хамтарсан VLab төвийн бүсийн уулзалт

Багш нар: Дэлхийн Цаг Уурын байгууллагын албан хаагч, Хятадын шинжлэх ухааны академийн профессор, Хятадын цаг уурын байгууллагын сургалтын төвийн дарга, багш нар, болон Хятадын Үндэсний цаг уурын хиймэл дагуулын төвийн дарга, инженерүүд оролцсон.

Сургалтын бүх үйл явц Нислэгийн цаг уурын төвийн сургалтын танхимд цахим хэлбэрээр явагдсан.

Сургалтаар Хятадын цаг уурын байгууллага болон Хятадын Үндэсний цаг уурын хиймэл дагуулын төвтэй товч танилцсан. Уур амьсгалын өөрчлөлт болон цаг агаарын үзэгдлүүдийг хиймэл дагуулын бичил долгионы тусламжтайгаар зайнаас тандан судлах, хиймэл дагуулын мэдээг ашиглан тоон прогнозын бүтээгдэхүүний алхамын нарийвчлал өндөртэй, сүлжээ, тоног төхөөрөмж, моделийн шинэ хувилбарууд, цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан прогнолох, FУ-4 хиймэл дагуулын мэдээг ашиглан SMART-ийн шинэ платформыг практикт ашиглах болон олон төрлийн лекцүүд орсон.

Уг сургалтанд цахимаар 120 цаг уурчид, синоптик инженерүүд болон цаг уурын байгууллагуудын дарга, менежерүүд хамрагдсан.

**Дүгнэлт:**

Энэхүү олон улсын сургалтанд сууснаар хөгжиж буй болон бусад улс орнуудаас нислэгийн цаг уурын урьдчилсан мэдээнд болон бусад холбогдох талбарт ажиллаж буй цаг уурчидтай туршлага солилцож, мэдээлэл хуваалцсан. Энэ сургалт нь хиймэл дагуулын мэдээг ашиглан цаг агаарын нөхцөл байдлыг шинжлэх, цаг агаарын үзэгдэл, параметруудийг урьдчилан мэдээллэх, цаг агаарын аюултай үзэгдлийг хэт богино хугацаанд урьдчилан мэдээлэх, ур чадварыг дээшлүүлэх, хиймэл дагуулын өгөгдлүүдийг мэдээний таарцыг сайжруулахад тусалсан. Мөн FY хиймэл дагуулын мэдээг SMART програм ашиглан нэмэлт боловсруулалт хийх боломжтой. Одоо манай улс FY2 хиймэл дагуулын мэдээг ашиглаж байгаа бөгөөд цаашид Хятадын цаг уурын байгууллагад хүсэлт тавьснаар FY4 хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг ашиглах бүрэн боломжтой юм.

Цаашид хийх ажил:

1. Мэргэжлийн хичээлийн хөтөлбөр боловсруулж МҮХ-ийн синоптик инженерүүдэд сургалт зохион байгуулах
2. Хиймэл дагуулын SMART системийг нарийвчлан судлах
3. Хятадын цаг уурын байгууллагат хүсэлт тавьж FY4 хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг судалж ашиглах

Тайлан бичсэн:

НЦУТ-ийн ахлах синоптик инженер  
НЦУТ-ийн ахлах синоптик инженер  
НЦУТ-ийн ахлах синоптик инженер  
НЦУТ-ийн синоптик инженер  
НЦУТ-ийн синоптик инженер

Б.Тэмүлүн  
Б.Батцэцэг  
Б.Солонго  
П.Хэрлэнчимэг  
Ц.Аззаяа